

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

## Агуулга

1. Аудитын гэрчилгээ.....	2
2. Аудитын тайлан.....	3
2.1. Оршил .....	3
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	3
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	3
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	4
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	4
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	4
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	5
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	5
2.9. Зорилтот түвшин, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	6
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	6
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	6
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	7
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт .....	7
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	7
3. Менежментийн захидал.....	8
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан .....	10
4.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	10
4.2. Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	12
4.3. Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	14
4.4. Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	16
4.5. Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	17
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	19

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандар
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

2020.03.13 № 06/811  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Худалдаа үйлдвэрлэлийн их сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Худалдаа үйлдвэрлэлийн их сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Худалдаа үйлдвэрлэлийн их сургуулийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Үүрэг, хариуцлага

Худалдаа үйлдвэрлэлийн их сургууль нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Худалдаа үйлдвэрлэлийн их сургууль нь зорилгоо “Инновац, энтрепренершип, тогтвортой, ногоон хөгжлийн концепцид суурилсан сургалт, эрдэм шинжилгээг хослуулж хөдөлмөрийн зах зээлд тэргүүлэгч мэргэжилтэн бэлтгэх” гэж тодорхойлжээ.

Дээрх зорилгын хүрээнд үйл ажиллагааны чиглэлээ дараах байдлаар тодорхойлжээ.  
Үүнд:

- “Судалгаанд суурилсан их сургууль” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх;
- Олон Улсын болон Үндэсний хэмжээний судалгааны грант бүхий төсөл удирддаг, оролцдог байх;
- Реер review хийгддэг олон улсын сэтгүүлд хэвлүүлдэг бүтээлийн тоог нэмэгдүүлэх.
- Олон Улсын жишигт нийцүүлэн сургалтын төлөвлөгөө хөтөлбөрийг өөрчилж, сайжруулах;
- Даян дэлхийн тогтвортой хөгжлийн хөтөлбөр, Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030, Боловсролын талаар төрөөс баримтлах бодлого, сургуулийн алсын хараа эрхэм зорилготой уялдуулан сургалтын үйл ажиллагааг явуулах;
- Сургалт судалгаа, үйлдвэрлэлийн түншлэлд түшиглэсэн Олон Улсын Стандартад нийцсэн тэгш хүртээмжтэй чанартай боловсролын үйлчилгээ үзүүлэх;
- “Орлоготой оюутан” хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах;
- Амьдралын зөв дадал хэвшилтэй эерэг хандлагатай идэвх санаачилгатай байгаль орчинд ээлтэй оюутныг төлөвшүүлэх;

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын Их Хурлын 2018 оны 80 дугаар тогтоолоор “Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай”
- Монгол Улсын Сангийн сайдын 2018 оны 301 дүгээр тушаал “Зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай”
- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоол “Журам шинэчлэн батлах тухай”
- Худалдаа үйлдвэрлэлийн их сургуулийн удирдах зөвлөлийн 2018 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 15 дугаар тогтоол “Төсөв батлах тухай”

## **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус их сургуулийн одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна

Худалдаа үйлдвэрлэлийн их сургууль нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Повер софт” программ хангамж ашигладаг байна.

Худалдаа үйлдвэрлэлийн их сургуулийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

## **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитаар Худалдаа үйлдвэрлэлийн их сургуулийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй

нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 12 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 1,635.3 сая төгрөгөөс тооцон 16.4 сая төгрөгөөр материаллаг байдлын түвшнийг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаас тооцож материаллаг байдлын түвшнийг 24.0 сая төгрөгөөр тогтоолоо.

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Худалдаа үйлдвэрлэлийн их сургуулийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 184.0 сая төгрөгөөр буюу 1.9 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	760.7	935.8	175.1
Авлага	195.0	105.7	(89.3)
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	153.1	170.6	17.5
Урт хугацаат хөрөнгө оруулалт	100.0	100.0	-
Үндсэн хөрөнгө	8,446.0	8,526.8	80.8
<b>Нийт хөрөнгө</b>	<b>9,654.9</b>	<b>9,838.9</b>	<b>184.0</b>
Өр төлбөр	13.9	47.0	33.1
Урьдчилж орсон орлого	526.4	379.5	(146.9)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	9,114.5	9,412.3	297.8
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>9,654.8</b>	<b>9,838.9</b>	<b>184.0</b>

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 175.1 сая төгрөгөөр өссөн нь тайлант оны орлого, давсан орлогын зарцуулаагүй үлдэгдэл зэрэг байна.

Авлага дансны үлдэгдэл 89.3 сая төгрөгөөр буурсан нь авлагыг барагдуулах ажлыг зохион байгуулж, байгууллага, хувь хүмүүстэй хийх тооцоог барагдуулснаас шалтгаалсан байна. Тухайлбал: Төлбөртэй үйлчилгээний авлага 29.8 сая, байгууллага хувь хүмүүстэй хийх тооцооны авлага 70.0 сая төгрөгийг барагдуулснаас шалтгаалсан байна.

Бараа материал дансны үлдэгдэл өссөн нь тус сургууль байгуулагдсаны түүхт 95 жилийн ойгоор үе үеийн төгсөгчид 7.0 сая төгрөгийн материал, хувь хүмүүсээс хүлээн авч орлогод бүртгэсэн 10.0 сая төгрөгийн бараа материалаар нэмэгдсэнтэй холбоотой.

Үндсэн хөрөнгө дансанд өөрийн хөрөнгөөр 31.7 сая төгрөгийн сургалтын тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, ном сурах бичиг, хандиваар хийсэн анги танхимын их засвар, тохижуулалт зэрэгт 197.1 сая төгрөгийн хөрөнгөөр тус тус нэмэгдсэн байна.

Өр төлбөр өмнөх оноос 33,1 сая төгрөгөөр нэмэгдсэн нь Баянхонгор аймаг дахь салбар сургуулийн татвар, нийгмийн даатгал, халаалт дулааны зардалд 36.9 сая төгрөгийн өр төлбөр үүссэнээс шалтгаалсан байна.

Урьдчилж орсон орлого дансны үлдэгдэл буурсан нь тухайн хичээлийн жилд 180 оюутан элсүүлэх төлөвлөгөө батлагдаж гүйцэтгэлээр 50 оюутан элссэнээс шалтгаалсан байна.

## **2.9. Зорилтот түвшин, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Худалдаа үйлдвэрлэлийн их сургуулийн удирдах зөвлөлийн 2018 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 15 дугаар тогтоолоор 2019 оны орлого, зарлагын төсөв баталсан. Үүнд: улсын төсвийн санхүүжилт 175.5 сая, орон нутгийн төсвөөс 32.8 сая, үндсэн үйл ажиллагааны орлого 1,706.0 сая, туслах үйл ажиллагааны орлого 488.9 сая, мөнгөн хөрөнгийн харилцах дансны үлдэгдлээс 673.8 сая төгрөгийг санхүүжүүлэхээр 3,077.0 сая төгрөгийн орлогын, цалин хөлсний зардалд 2,044.3 сая, бараа үйлчилгээний зардалд 292.7 сая, сургалт үйлчилгээний зардалд 238.2 сая төгрөг, судалгаа, эрдэм шинжилгээний зардалд 76.3 сая, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 243.8 сая, хөрөнгө зардалд 180.4 сая төгрөг нийт 3,075.7 сая төгрөг зарцуулах төсөв батлагдсан байна.

Орлогын гүйцэтгэл нь улсын төсвийн санхүүжилт 212.0 сая төгрөг буюу 20.7 хувь, орон нутгийн төсвөөс 62.4 сая төгрөг буюу 90.2 хувиар давж биелсэн, үндсэн үйл ажиллагааны орлого 1,429.0 сая төгрөг буюу 16.2 хувь, туслах үйл ажиллагааны орлого 475.2 сая төгрөг буюу 2.8 хувиар тасарсан, нийт 2,178.6 сая төгрөгийн орлого бүрдүүлж ажиллажээ.

Тайлант оны нийт зардлын гүйцэтгэл 2,003.5 сая төгрөг буюу 65.1 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь цалин хөлсний зардлаас 554.2 сая, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлаас 76.6 сая, сургалт үйлчилгээний зардлаас 125.7 сая, судалгаа эрдэм шинжилгээний зардлаас 42.3 сая, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлаас 44.0 сая төгрөгийг дутуу зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлыг зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

## **2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 12 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 1 эрсдэл нэмж тодорхойлж нийт 13 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 96.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 1.2 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 95.1 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгч байна. Үүнээс:

1. Ажилтны цалин, ээлжийн амралтын олговрыг давхардуулж 1.2 сая төгрөгийг илүү олгосон нь Хөдөлмөрийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.1-д "Ажилтанд жил бүр ээлжийн амралт олгож биеэр эдлүүлнэ", Эрүүл мэнд Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн сайдын 2000 оны 166-р тушаалаар баталсан "Ээлжийн амралт олгох заавар" 2-д "Ажил олгогч нь бүх ажилтныг ажлын жил бүр ээлжийн амралтаа заавал биеэр эдлэх бололцоогоор хангаж, эдлүүлнэ" гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "үнэн зөв байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх, холбогдох эздээр нөхөн төлүүлэхээр төлбөрийн акт тогтоосон.

## **2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Анхаарал татахуйц асуудал гараагүй.

## **2.12. Шилэн дансны мэдээлэл**

Худалдаа үйлдвэрлэлийн их сургууль нь шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд зааснаар 116 мэдээллийг хугацаанд нь байршуулсан байна.

## **2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 21.2 сая төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлага өгснийг хэрэгжүүлсэн байна.

Нийт 3 зөвлөмж өгснөөс 3 зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан, хэрэгжилт 100 хувьтай байна.

## **2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Худалдаа үйлдвэрлэлийн их сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Худалдаа үйлдвэрлэлийн их сургуулийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.



### **3. Менежментийн захидал**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга нь АДБОУС болон аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### **1. Байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагаатай холбоотой асуудал**

##### 1.1.Илрүүлэлт:

Байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгүүдийг бодит үнэ цэнээр нь үнэлэх, ашиглагдах жилийг шинэчлэх талаар Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хандан шийдвэрлүүлээгүй байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 7.1-д “Төрийн өмчийн хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэж Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ” гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “Оршин байх”, “Үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

##### 1.2.Эрсдэл:

Санхүүгийн тайлан үнэн бодитой илэрхийлэгдэхгүй байх, хөрөнгийн ашиглалт алдагдах, хөрөнгийг бодит үнэ цэнээр нь үнэлж бүртгээгүй байх;

##### 1.3.Өгсөн зөвлөмж:

Дээрх зөрчлийг гаргахгүй байх, хөрөнгийн үнэ болон ашиглагдах жилийг шинэчлэн тогтоох.

##### 1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Худалдаа үйлдвэрлэлийн их сургуулийн 2020 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 12 тоот албан бичгээр алдаа зөрчлийг хүлээн зөвшөөрсөн.

#### **2. Балансын данстай холбоотой асуудал**

##### 2.1.Илрүүлэлт:

Өмнөх онд үүссэн Боловсрол соёл, шинжлэх ухаан спортын яамнаас авах 95.1 сая төгрөгийн авлага барагдаагүй, тооцоо нийлж ажиллаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “Оршин байх”, “Иж бүрэн байх”, “Үнэн зөв байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### 2.2.Эрсдэл:

Авлагын тооцоог баталгаажуулаагүй аль нэг тал хүлээн зөвшөөрөөгүй байх;

#### 2.3.Өгсөн зөвлөмж:

Дээрх авлагатай холбоотой ажлыг зохион байгуулж ажиллах.

#### 2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Худалдаа үйлдвэрлэлийн их сургуулийн 2020 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 12 тоот албан бичгээр алдаа зөрчлийг хүлээн зөвшөөрсөн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

##### 4.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,108,792,534.79</b>	<b>1,212,114,271.87</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>760,651,353.52</b>	<b>935,768,412.38</b>
<b>31200</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>87,013,408.53</b>	<b>535,768,412.38</b>
<b>31210</b>	<b>Төгрөг</b>	<b>87,013,408.53</b>	<b>535,768,412.38</b>
31213	Арилжааны банк дахь харилцах	87,013,408.53	535,768,412.38
31500	Хадгаламж	673,637,944.99	400,000,000.00
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>194,956,386.83</b>	<b>105,718,543.32</b>
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	29,771,650.00	240,000.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	95,180,663.06	95,180,663.06
<b>33500</b>	<b>Бусад авлага</b>	<b>70,004,073.77</b>	<b>10,297,880.26</b>
33510	Байгууллагаас авах авлага	41,681,008.12	10,297,880.26
33520	Хувь хүмүүсээс авах авлага	28,323,065.65	-
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>153,184,794.44</b>	<b>170,627,316.17</b>
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>153,184,794.44</b>	<b>170,627,316.17</b>
35420	Аж ахуйн материал	16,819,380.36	17,113,059.62
35430	Сэлбэг хэрэгсэл	-	120,000.00
35450	Барилгын засварын материал	96,986.20	909,498.95
35470	Бусад хангамжийн материал	136,268,427.88	152,484,757.60
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>8,546,063,669.00</b>	<b>8,626,791,595.07</b>
<b>37</b>	<b>УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ</b>	<b>100,000,000.00</b>	<b>100,000,000.00</b>
<b>37200</b>	<b>Үнэт цаас</b>	<b>100,000,000.00</b>	<b>100,000,000.00</b>
37210	Хувьцаа	100,000,000.00	100,000,000.00
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>8,446,063,669.00</b>	<b>8,526,791,595.07</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>6,359,708,502.41</b>	<b>6,441,466,428.56</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	5,801,785,200.00	6,153,525,178.59
39202	Хуримтлагдсан элэгдэл	-	(285,042,262.56)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	36,299,500.00	36,299,500.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(36,299,500.00)	(36,299,500.00)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	409,955,719.21	406,393,335.21
39206	Хуримтлагдсан элэгдэл	(297,978,629.84)	(305,178,926.32)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	458,500,884.71	500,528,067.85
39208	Хуримтлагдсан элэгдэл	(327,999,666.27)	(353,215,317.19)
39209	Зам, гүүрийн байгууламж	23,279,364.50	28,979,364.50
39210	Хуримтлагдсан элэгдэл	(21,991,048.25)	(22,693,183.25)
39214	Бусад үндсэн хөрөнгө	33,575,500.00	41,575,500.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-	(9,791,706.62)
39217	Ном	280,581,178.35	286,386,378.35
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>2,086,355,166.59</b>	<b>2,085,325,166.51</b>
39301	Программ хангамж	7,520,000.00	7,520,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(3,993,333.41)	(5,023,333.49)
39303	Бусад биет бус хөрөнгө	2,082,828,500.00	2,082,828,500.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>9,654,856,203.79</b>	<b>9,838,905,866.94</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>540,318,099.56</b>	<b>426,534,587.38</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>540,318,099.56</b>	<b>426,534,587.38</b>
<b>41300</b>	<b>Өглөг</b>	<b>13,884,474.69</b>	<b>47,006,700.38</b>

Худалдаа үйлдвэрлэлийн их сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	13,884,474.69	16,749,333.00
<b>41360</b>	<b>Бусад өглөг</b>	-	<b>30,257,367.38</b>
41363	Татварын өглөг /ТӨҮГ/	-	6,040,185.79
41364	НДШ-ийн өглөг /ТӨҮГ/	-	24,217,181.59
<b>41400</b>	<b>Урьдчилж орсон орлого</b>	<b>526,433,624.87</b>	<b>379,527,887.00</b>
41420	Төлбөртэй ажил үйлчилгээний урьдчилж орсон орлого	526,433,624.87	356,527,887.00
41440	Бусад урьдчилж орсон орлого	-	23,000,000.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>9,114,538,104.23</b>	<b>9,412,371,279.56</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>9,114,538,104.23</b>	<b>9,412,371,279.56</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	5,640,076,523.69	5,640,076,523.69
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>389,241,767.28</b>	<b>671,345,087.10</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	334,906,380.96	373,511,911.77
51220	Тайлант үеийн үр дүн	54,335,386.32	297,833,175.33
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,085,219,813.26	3,100,949,668.77
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>9,654,856,203.79</b>	<b>9,838,905,866.94</b>

#### 4.2. Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,689,668,884.57</b>	<b>2,707,829,193.03</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,372,197,074.51</b>	<b>2,212,328,993.03</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>1,371,597,074.51</b>	<b>2,007,780,964.03</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>1,371,597,074.51</b>	<b>2,007,780,964.03</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,030,180,029.63	1,512,517,813.87
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	341,417,044.88	495,263,150.16
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	<b>600,000.00</b>	<b>204,548,029.00</b>
122001	Хандив тусламж /дотоод/	600,000.00	204,548,029.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>317,471,810.06</b>	<b>495,500,200.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>115,028,100.00</b>	<b>208,288,800.00</b>
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	115,028,100.00	208,288,800.00
<b>1330</b>	<b>Төсвийн захирагчдаас</b>	<b>202,443,710.06</b>	<b>287,211,400.00</b>
133004	Төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилт	150,403,490.06	237,292,800.00
133005	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт	52,040,220.00	49,918,600.00
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,635,333,498.25</b>	<b>2,409,996,017.70</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,635,333,498.25</b>	<b>2,409,996,017.70</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,599,065,433.25</b>	<b>2,355,779,693.70</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>867,281,408.58</b>	<b>1,282,675,231.46</b>
210101	Үндсэн цалин	867,281,408.58	1,282,675,231.46
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>109,910,178.70</b>	<b>161,368,948.58</b>
210201	Тэтгэврийн даатгал	69,942,840.97	109,027,394.67
210202	Тэтгэмжийн даатгал	7,993,467.53	10,261,401.85
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,991,834.44	12,826,752.31
210204	Ажилгүйдлийн даатгал	1,998,366.87	2,565,350.46
210205	Эрүүл мэндийн даатгал	19,983,668.89	26,688,049.29
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>141,878,047.06</b>	<b>145,514,378.12</b>
210301	Гэрэл, цахилгаан	50,318,610.28	51,346,249.42
210302	Түлш, халаалт	69,278,540.00	64,433,451.90
210303	Цэвэр, бохир ус	22,280,896.78	29,734,676.80
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>30,391,093.40</b>	<b>47,063,846.28</b>
210401	Бичиг хэрэг	1,300,690.00	1,590,511.18
210402	Тээвэр, шатахуун	5,624,365.00	8,447,910.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	11,114,054.29	16,499,483.30
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	12,351,984.11	20,525,941.80
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>19,869,202.19</b>	<b>61,822,536.25</b>
210604	Урсгал засвар	19,869,202.19	61,822,536.25
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>15,062,702.00</b>	<b>12,269,136.00</b>
210702	Дотоод албан томилолт	4,726,500.00	4,826,900.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	10,336,202.00	7,442,236.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>130,463,807.52</b>	<b>80,029,391.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	121,231,367.52	74,660,991.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	99,100.00	129,600.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	9,133,340.00	5,238,800.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>284,208,993.80</b>	<b>565,036,226.01</b>

Худалдаа үйлдвэрлэлийн их сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,813,900.00	57,628,364.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	113,683,804.23	137,152,636.49
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	155,711,289.57	370,255,225.52
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>36,268,065.00</b>	<b>54,216,324.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>36,268,065.00</b>	<b>54,216,324.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	36,268,065.00	54,216,324.00
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>54,335,386.32</b>	<b>297,833,175.33</b>
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>54,335,386.32</b>	<b>297,833,175.33</b>

#### 4.3. Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,846,781,868.67</b>	<b>2,178,659,526.02</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,629,836,298.67</b>	<b>1,904,240,126.02</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>1,629,236,298.67</b>	<b>1,883,347,187.02</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>1,629,236,298.67</b>	<b>1,883,347,187.02</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,179,360,805.50	1,429,042,536.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	449,875,493.17	454,304,651.02
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	<b>600,000.00</b>	<b>20,892,939.00</b>
122001	Хандив тусламж /дотоод/	600,000.00	20,892,939.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>216,945,570.00</b>	<b>274,419,400.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>124,905,350.00</b>	<b>212,042,800.00</b>
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	124,905,350.00	212,042,800.00
<b>1330</b>	<b>Төсвийн захирагчдаас</b>	<b>92,040,220.00</b>	<b>62,376,600.00</b>
133004	Төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилт	40,000,000.00	12,458,000.00
133005	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт	52,040,220.00	49,918,600.00
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,464,660,022.09</b>	<b>1,971,851,017.16</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,464,660,022.09</b>	<b>1,971,851,017.16</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,431,595,257.09</b>	<b>1,919,558,797.16</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>851,717,756.39</b>	<b>1,265,239,651.89</b>
210101	Үндсэн цалин	851,717,756.39	1,265,239,651.89
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>126,259,475.85</b>	<b>148,227,424.85</b>
210201	Тэтгэврийн даатгал	80,346,939.15	97,617,838.77
210202	Тэтгэмжийн даатгал	9,182,507.32	10,121,917.22
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,478,134.19	12,652,396.52
210204	Ажилгүйдлийн даатгал	2,295,626.82	2,530,479.30
210205	Эрүүл мэндийн даатгал	22,956,268.37	25,304,793.04
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>125,771,088.32</b>	<b>145,163,178.12</b>
210301	Гэрэл, цахилгаан	47,247,710.23	50,058,922.42
210302	Түлш, халаалт	56,157,794.76	65,369,578.90
210303	Цэвэр, бохир ус	22,365,583.33	29,734,676.80
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>35,930,813.29</b>	<b>50,483,260.30</b>
210401	Бичиг хэрэг	3,464,140.00	1,924,115.00
210402	Тээвэр, шатахуун	5,624,365.00	8,482,910.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	11,175,304.29	16,499,483.30
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	15,667,004.00	23,576,752.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>50,666,627.54</b>	<b>23,346,049.00</b>
210604	Урсгал засвар	50,666,627.54	23,346,049.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>9,438,662.00</b>	<b>11,332,416.00</b>
210702	Дотоод албан томилолт	4,332,260.00	4,049,400.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	5,106,402.00	7,283,016.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>73,873,100.00</b>	<b>79,717,791.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	73,774,000.00	74,478,991.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	99,100.00	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	0.00	5,238,800.00

<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>157,937,733.70</b>	<b>196,049,026.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	113,527,491.70	63,827,995.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	44,410,242.00	132,221,031.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>33,064,765.00</b>	<b>52,292,220.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>33,064,765.00</b>	<b>52,292,220.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	36,200,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	33,064,765.00	16,092,020.00
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>382,121,846.58</b>	<b>206,808,508.86</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>45,288,351.00</b>	<b>31,691,450.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>45,288,351.00</b>	<b>31,691,450.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>45,288,351.00</b>	<b>31,691,450.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	45,288,351.00	31,691,450.00
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>(45,288,351.00)</b>	<b>(31,691,450.00)</b>
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>336,833,495.58</b>	<b>175,117,058.86</b>
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	423,817,857.94	760,651,353.52
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	760,651,353.52	935,768,412.38



**4.4. Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>1</b>	<b>2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>3,590,401,523.69</b>	-	<b>334,906,380.96</b>	<b>3,925,307,904.65</b>
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,590,401,523.69	-	334,906,380.96	3,925,307,904.65
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	3,085,219,813.26	-	3,085,219,813.26
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	2,049,675,000.00	-	-	2,049,675,000.00
7	Өмчид гарсан өөрчилөлт	-	-	-	-
9	Тайлант үеийн үр дүн	-	-	54,335,386.32	54,335,386.32
<b>10</b>	<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>5,640,076,523.69</b>	<b>3,085,219,813.26</b>	<b>389,241,767.28</b>	<b>9,114,538,104.23</b>
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,640,076,523.69	3,085,219,813.26	389,241,767.28	9,114,538,104.23
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	15,729,855.51	-15,729,855.51	-
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
19	Тайлант үеийн үр дүн	-	-	297,833,175.33	297,833,175.33
<b>20</b>	<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>5,640,076,523.69</b>	<b>3,100,949,668.77</b>	<b>671,345,087.10</b>	<b>9,412,371,279.56</b>

#### 4.5. Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		<b>760 651 353,52</b>		
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>3 075 692 500,00</b>	<b>2 003 905 509,16</b>	<b>1 071 786 990,84</b>	65,1
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2 895 245 100,00</b>	<b>1 972 214 059,16</b>	<b>923 031 040,84</b>	68,1
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2 836 040 700,00</b>	<b>1 919 558 797,16</b>	<b>916 481 902,84</b>	67,6
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1 819 502 000,00</b>	<b>1 265 239 651,89</b>	<b>554 262 348,11</b>	69,5
210101	Үндсэн цалин	1 819 502 000,00	1 265 239 651,89	554 262 348,11	69,5
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>224 852 500,00</b>	<b>148 227 424,85</b>	<b>76 625 075,15</b>	65,9
210201	Тэтгэврийн даатгал	152 072 420,00	97 617 838,77	54 454 581,23	64,1
210202	Тэтгэмжийн даатгал	14 556 016,00	10 121 917,22	4 434 098,78	69,5
210203	ҮОМШӨ-ний даатгал	18 195 020,00	12 652 396,52	5 542 623,48	69,5
210204	Ажилгүйдлийн даатгал	3 639 004,00	2 530 479,30	1 108 524,70	69,5
210205	Эрүүл мэндийн даатгал	36 390 040,00	25 304 793,04	11 085 246,96	69,5
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>197 339 200,00</b>	<b>153 338 178,12</b>	<b>44 001 021,88</b>	77,7
210301	Гэрэл, цахилгаан	49 440 000,00	50 058 922,42	(618 922,42)	101,2
210302	Түлш, халаалт	96 347 200,00	65 369 578,90	30 977 621,10	67,8
210303	Цэвэр, бохир ус	25 795 300,00	29 734 676,80	(3 939 376,80)	115,2
210304	Байрны түрээс	25 756 700,00	8 175 000,00	17 581 700,00	31,7
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>83 775 200,00</b>	<b>50 483 260,30</b>	<b>33 291 939,70</b>	60,2
210401	Бичиг хэрэг	22 450 000,00	1 924 115,00	20 525 885,00	8,5
210402	Тээвэр, шатахуун	9 785 600,00	8 482 910,00	1 302 690,00	86,6
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	25 276 800,00	16 499 483,30	8 777 316,70	65,2
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	26 262 800,00	23 576 752,00	2 686 048,00	
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>40 000 000,00</b>	<b>23 346 049,00</b>	<b>16 653 951,00</b>	58,3
210604	Урсгал засвар	40 000 000,00	23 346 049,00	16 653 951,00	58,3
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>54 001 000,00</b>	<b>11 332 416,00</b>	<b>42 668 584,00</b>	20,9
210702	Дотоод албан томилолт	7 500 000,00	4 049 400,00	3 450 600,00	53,9
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	46 501 000,00	7 283 016,00	39 217 984,00	15,6
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>84 386 000,00</b>	<b>79 717 791,00</b>	<b>4 668 209,00</b>	94,4
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	72 186 000,00	74 478 991,00	(2 292 991,00)	103,1
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	12 200 000,00	5 238 800,00		

<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>332 184 800,00</b>	<b>187 874 026,00</b>	<b>144 310 774,00</b>	56,5
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	60 134 300,00	55 652 995,00	4 481 305,00	
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	272 050 500,00	132 221 031,00	139 829 469,00	48,6
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>59 204 400,00</b>	<b>52 655 262,00</b>	<b>6 549 138,00</b>	88,9
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>59 204 400,00</b>	<b>52 655 262,00</b>	<b>6 549 138,00</b>	88,9
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	45 204 400,00	44 200 200,00	1 004 200,00	97,7
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	14 000 000,00	8 455 062,00	5 544 938,00	60,3
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>180 447 400,00</b>	<b>31 691 450,00</b>	<b>148 755 950,00</b>	17,5
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>180 447 400,00</b>	<b>31 691 450,00</b>	<b>148 755 950,00</b>	17,5
220001	Барилга байгууламж	29 466 500,00	6 000 000,00	23 466 500,00	20,3
222001	Тоног төхөөрөмж	81 990 900,00	10 885 650,00	71 105 250,00	13,2
223001	Бусад хөрөнгө	68 990 000,00	14 805 800,00	54 184 200,00	21,4
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>2 227 748 600,00</b>	<b>2 179 022 568,02</b>	<b>48 726 031,98</b>	
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	-	<b>12 458 000,00</b>	<b>(12 458 000,00)</b>	
131001	Улсын төсвөөс санхүүжих		12 458 000,00	(12 458 000,00)	
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	32 777 600,00	49 918 600,00	(17 141 000,00)	152,2
132001	Орон нутгийн төсвөөс	32 777 600,00	49 918 600,00	(17 141 000,00)	152,2
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>2 194 971 000,00</b>	<b>2 116 645 968,02</b>	<b>78 325 031,98</b>	96,4
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1 706 065 400,00	1 638 061 336,00	68 004 064,00	96,0
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	488 905 600,00	478 584 632,02	10 320 967,98	97,8
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>673 773 500,00</b>	<b>760 651 353,52</b>		
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>1 295 200,00</b>	<b>935 768 412,38</b>		

**5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт**

Огноо:	Аудитын нэр:	<b>Худалдаа үйлдвэрлэлийн их сургуулийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит</b>	Аудитын код:
2019			САГ-2020/83/СТА-ТӨҮГ
Шалгагдсан байгууллагын нэр:	Худалдаа үйлдвэрлэлийн их сургууль		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн /сая төгрөг/	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Нэр бүхий 4 ажилчдын цалин, ээлжийн амралтын олговрыг давхардуулж 1.2 сая төгрөгийг илүү олгосон	1.2	Төлбөрийн акт тогтоох	Захирал Нягтлан бодогч	М.Должин Л.Гоёцэцэг
2	Өмнөх онд үүссэн Боловсрол соёл, шинжлэх ухаан спортын яамнаас авах 95.1 сая төгрөгийн авлага барагдаагүй, тооцоо нийлж ажиллаагүй	95.1	Зөвлөмж өгөх	Захирал Нягтлан бодогч	М.Должин Л.Гоёцэцэг
3	Байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгүүдийн үнэ болон ашиглагдах жилийг шинэчлэх талаар Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хандан шийдвэрлүүлээгүй байна.	-	Зөвлөмж өгөх	Захирал Нягтлан бодогч	М.Должин Л.Гоёцэцэг
<b>НИЙТ ДҮН</b>		<b>96.3</b>			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2020 оны 03 дугаар сарын 16

№ 02/54

Улаанбаатар хот

С А Г - 00 00 / 83 / С Т А - Т Ц 3


Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд, Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасан цаглабарт хугацаанд Худалдаа үйлдвэрлэлийн их сургуулийн 2019 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ажилтны ээлжийн амралтыг биеэр эдлүүлээгүй, цалин, ээлжийн амралтын олговрыг давхардуулж, 1,200,000.00 төгрөгөөр илүү олгосон нь Хөдөлмөрийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.1-д "Ажилтанд жил бүр ээлжийн амралт олгож биеэр эдлүүлнэ", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-т "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Эрүүл мэнд Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн сайдын 2000 оны 166-р тушаалаар баталсан "Ээлжийн амралт олгох заавар" 2-д "Ажил олгогч нь бүх ажилтныг ажлын жил бүр ээлжийн амралтаа заавал биеэр эдлэх бололцоогоор хангаж, эдлүүлнэ" гэсэн заалтыг зөрчсөн.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт, албан шаардлага өгөх..." Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3.1-д "...дараах алдаа зөрчилд төрийн аудитын байгууллага төлбөрийн акт тогтооно гэсэн заалтуудыг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Цалин, ээлжийн амралтыг давхардуулан илүү олгосон 1,200,000.00 (нэг саян хоёр зуун мянган) төгрөгийг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлж төсвийн орлого болгох актын төлбөрийг Үндэсний аудитын газрын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх,
2. Төлбөрийн актын биелэлтийг 2020 оны 6 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Худалдаа үйлдвэрлэлийн их сургуулийн захирал М.Должин, нягтлан бодогч Л.Гоёцэцэг нарт хариуцуулав.




**ТОГТООСОН:**  
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ  
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

УВАА УУЛ АУДИТ ХХК  
ЗАХИРАЛ Ч МӨНХТУЯА

АКТ



**ЗӨВШӨӨРСӨН:**  
ХУДАЛДАА ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ИХ  
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ

М.ДОЛЖИН

АХЛАХ НИЯГТЛАН БОДОГЧ  
Л.ГОЁЦЭЦЭГ

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.

\\10.10.10.20\Bichig\_Khereg\Akt\2020\0313SAG2.Docx

001090122





